- Судалгаа шинжилгээний үр дүнг нийтийн хүртээл болгох, хэвлэн нийтлүүлэх, шинэ бүтээл болон дэвшилтэт технологийг мэдлэгийг патентлуулж оюуны өмчийг баталгаажуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус хүрээлэн үйл ажиллагаандаа Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Инновацийн тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Архивын тухай хууль, Иргэний хууль, Шилэн дансны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд хүрээлэнгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- Сангийн сайдын 2025 оны А/03 тоот тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам;

Хүрээлэнгийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний САГ-2026/104/НА-СТА-ТШЗ

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хүрээлэнд дотоод аудиторын орон тоо байхгүй, Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийдэг ба 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хүрээлэнгийн мөрдөж буй Монгол улсын Тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/113 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-нь стандартад нийцсэн боловч үйл ажиллагааны онцлогт бүрэн тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 197,934.2 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	195,861.1	73,170.2	(122,690.9)
Урьдчилгаа	9,800.9	-	(9,800.9)
Бараа материал	45,812.5	18,448.7	(27,363.9)
Үндсэн хөрөнгө	4,451,316.1	4,809,105.9	357,789.8
Нийт хөрөнгө	4,702,790.6	4,900,724.8	197,934.2
Өр төлбөр	18,130.1	36,230.1	18,100.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,684,660.5	4,864,494.7	179,834.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө /өмчийн дүн	4,702,790.6	4,900,724.8	197,934.2

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт дараах данснуудад байна. Тухайлбал:

- Тайлант онд ШУТС-аас авсан 193,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага, 2,861.1 мянган төгрөгийн томилолтын авлагыг барагдуулсан. Мал эмнэлгийн ерөнхий газартай хийгдсэн гэрээний дагуу орж ирсэн 72,000.00 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт төвлөрүүлж, Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна. Мөн ХХОАТ-ын 1,170.2 мянган төгрөгийн авлага үүссэн байна.
- Томилолтын урьдчилгааны 9,800.9 мянган төгрөгийг тайлант онд барагдуулсан байна.
- Бараа материалын үлдэгдэл 27,363.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд шинээр 199,876.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 227,240.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой;
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 357,789.8 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2025 оны 735 дугаар тогтоолын дагуу ашиглалтын хугацаа дууссан, үлдэх өртөггүй байсан 66 нэр төрлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглах хугацааг сунган 778,220.3 мянган төгрөгөөр дахин үнэлж орлогод авсан мөн шинээр 19,593.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,300.0 мянган төгрөгийн тавилга худалдан авснаар нэмэгдэж, тайлант хугацаанд тооцсон 443,024.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан; Үүнээс биет бус хөрөнгөнд 1,200.0 төгрөгийн програм хангамж бүртгэлтэй байна;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 18,100.0 мянган төгрөгөөр өссөн нь санхүүжилтийн эрх нээгдэхгүй байснаас төлбөр тооцоогоо барагдуулаагүйгээс өр төлбөр нэмэгдсэн;
- Засгийн газрын хувь оролцооны дансны үлдэгдэл 4,900,724.8 мянган төгрөг болж 179,834.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэнгийн 2025 онд улсын төсвөөс авах нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,894,002.5 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчад санал хүргүүлсэн боловч 379,854.8 мянган төгрөгөөр бууруулж, төсвийг 3,514,147.7 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

Үүнээс, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалыг 185,361.9 мянган төгрөг, Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 41,410.00 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 10,896.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, эд хогшил, урсгал засварын зардлыг 535,279.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 54,724.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 11,012.4 мянган төгрөг, дотоодын албан томилолтын зардлыг 10,478.0 мянган төгрөг, норматив зардлыг 5,058.1 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь материаллаг хэмжээний голлох өөрчлөлтийг үзүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,514,147.7 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр урсгал төсвөөс 3,502,145.7 мянган төгрөгийн санхүүжилт авч 3,498,881.3 мянган төгрөгийг зарцуулж, 3,264.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,498,881.3 мянган төгрөг буюу 99.57 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 12,002.2 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 3,264.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71805	Шинжлэх ухаан, технологи нийт дүн	3,514,147.9	3,498,881.3	15,266.6	99.57
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,472,737.8	3,460,735.6	12,002.2	99.65
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	41,410.1	38,145.7	3,264.4	92.12

1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар

Тус хүрээлэнгийн бүтэц, орон тоог Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тоот тушаалаар нийт 94 албан хаагч ажиллахаар баталж, гүйцэтгэлээр 94 албан хаагч ажилласан байна. Тайлант онд Улсын их хурлын 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл"-д "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ" гэж заасны хэрэгжүүлээгүй, байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог 9.0 хувиар бууруулаагүй байна.

2. Унаа хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам", МЭЭШХ-ийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 03 өдрийн Б/14 тоот тушаал, үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээг тус тус үндэслэн унаа хоолны хөнгөлөлтийг өдрийн 30.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 548,452.1 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлснээс 211,730.0 мянган төгрөг нь ШУТС-ийн төслийн санхүүжилт, 336,722.1 мянган төгрөг нь МЭЭГ болон дотоодын гэрээт ажлын санхүүжилт байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 8,868.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 798.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 67,737.4 мянган төгрөг, норматив зардалд 159,681.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 20,689.9 мянган төгрөг, дотоод албан томилолтонд 159,939.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжинд 56,266.7 мянган төгрөг, нийт 473,981.9 мянган төгрөгийг зарцуулж, 74,470.2 мянган төгрөгийг улсын орлогод төвлөрүүлснээс 72,000.0 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар тооцоо нийлсэн байна.

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус хүрээлэн тайлант онд 7 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 211,730.0 мянган төгрөгийн зарцуулснаас 1 төсөл эхний шатанд хэрэгжиж байна. Үүнд:

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн биелэлт /мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Сүрьеэ, ям өвчний хяналт төсөл	2021-2025	Сүрьеэ, ям өвчнийг илрүүлэх хурдавчилсан оношлуур, ФХЭБҮ-ийн технологийг бий болгож, 13 аймгийн 3000 гаруй малд тандалт хийн халдварын тархалтыг тогтоох	Гүйцэтгэлийн үе шатанд	33,840.0	33,840.0
2	Адууны нийлүүлгийн өвчнийг хянах, эрүүлжүүлэх, тогтолцоог бий болгох судалгаа" төсөл	2025-2028	63 сумын 3500 адууны ийлдэс, цусны дээж цуглуулж, 68 малчнаас асуумж авч нэгтгэв. Төв аймгийн Сэргэлэн сумын малчдын дунд хяналт тавин ажиллаж байна.	Эхний шат	88,540.0	88,540.0
3	Монгол, Хятад дахь хонины махан ашиг шимийн хамтарсан судалгаа, хөгжүүлэлт" төсөл	2023-2025	Хонины амьдын жинг нэмэгдүүлэх технологи (бактери, дрожжийн хослол)-ийг боловсруулж, санал дүгнэлт гаргав.	Гүйцэтгэлийн үе шатанд	15,000.0	15,000.0
4	Калдвет бэлдмэлийн технологийн зүгшрүүлэлт ба туршилт" туршилт зүгшрүүлэлтийн төсөл	2023-2024	Хоёр барааны тэмдэг авч, үйлдвэрлэлийн горим боловсруулав. Мал, амьтны зориулалттай нийт 1000 гаруй тун	Гүйцэтгэлийн үе шатанд	5,900.0	5,900.0

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			бэлдмэл үйлдвэрлэж, танилцуулга сурталчилгааг эхлүүлэв.			
5	"Адууны пироплазмоз /хачгийн халуу/-ын үүсгэгчийн хоруу чанарт омгуудын лабораторийн өсгөвөр ялган авч генетик хэв шинжийг тодорхойлох , эх орны түүхий эд /ургамал , амьтаны /ээс ялгасан химийн нэгдлүүдийн эмчилгээний идэвхийг тус паразитын өсгөврүүд дээр турших нь "	2024-2026	Халуун өвчний үүсгэгчийн орон нутгийн омог ялган авч, тархалтын байршлыг тогтоов. Шаардлагатай урвалж, тоног төхөөрөмжийн захиалгыг хүлээн авсан.	Дунд шат	10,000.0	10,000.0
6	"Адууны болон бог малд шинээр сэргэж буй халдварт өвчнүүдийн рекомбинат оношлуурыг гарган авч хяналтын тогтолцоонд нэвтрүүлэх"	2024-2026	Адууны герпес вирусийн оношлуур, ФХЭБҮ цомгийг туршиж байна. Эрдэм шинжилгээний өгүүллүүд хэвлүүлж, оношлуурын захиалгыг хийв.	Дунд шат	15,000.0	15,000.0
7	"Нүүдэлчин Монголчуудын уламжлалт мэдлэгт тулгуурлан бэлчээрийн тэжээлийн зэрлэг ургамлын ашигтай хэрэглээгээр бэлчээрийг нөхөн сэргээх" САПРЕПС төсөл	2024-2026	1 патентын мэдүүлэг өгч, 2 фармакопейн өгүүлэл батлуулав. Түүхий эдийг стандартчилан, эрдэм шинжилгээний судалгааг олон улсад хэвлүүлэв.	Дунд шат	43,450.0	43,450.0
НИЙТ ДҮН					211,730.0	211,730.0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төгсгүүд консалтинг аудит ХХК-ийн аудитор А. Саранцэцэг, аудиторын туслах Ч. Мандахтуяа нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Т.Сарантуяа, компанийн захирал, аудитор Р. Даваа, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхжин, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аудит хийсэн 2024 оны жилийн эцсийн мөнгөн гүйлгээний тайлангаарх зардлын 3,510,323.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 35,103.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тэвчиж болох зардлуудыг гаргахгүй байх, зайлшгүй шаардлагатай зардлуудыг эрэмбэлэн зарцуулах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хязгаарласан 32 заалтуудыг хамруулан горим сорил хэрэгжүүлсэн, аудитаар зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 171 мэдээлэл байршуулахаас 169 мэдээлэл байршуулж, 2 мэдээлэлийн байршуулах хугацаа болоогүй байна. Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 4,174,405.8 мянган төгрөгийн 30 гүйлгээ, зарлагын 430,827.4 мянган төгрөгийн 25 гүйлгээг хуулийн хугацаанд иж бүрэн, ил тод мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, үндсэн хөрөнгийн данснуудад аудитын горим сорил хэрэгжүүлж, завсрын аудитаар илрүүлсэн 123,133.0 мянган төгрөгийн алдааг засаж залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн төлбөр барагдуулах 340.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг таслан зогсоох 5,149.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, алдааг засах 17,322.5 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	340.0	1	340.0	100.0
Албан шаардлага	2	5,149.4	2	5,149.4	100.0
Зөвлөмж	5	18,322.5	1	18,322.5	100.0
Нийт дүн	8	23,811.9	4	23,811.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

- Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
- Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,505.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд, 1,815.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,689.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 7,505.2 мянган төгрөгийн залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 27,598.0 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгч байна.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Төрийн албаны цалингийн нэгдсэн системд бодогдсон албан хаагчдын цалингаас 1,815.3 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгаж, төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалт хэрэгжүүлж, мэдээ, тайлангийн уялдааг нягтлан шалгаж хэвших", мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна", 7.1.1-д "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдын цалингаас хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгасан 1,815.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Зөвлөмж

Илрүүлэлт 1: Тайлант онд 5,689.9 мянган төгрөгийн хөрөнгийг нэмэлт төсвөөс худалдан авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр хөрөнгөнд бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 8.1 "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлнэ", 4.2-д "Төсөвт хуулийн этгээд нь Төсвийн тухай хуулийн батлагдсан урсгал төсөв, нэмэлт төсөв, хэмнэсэн төсөв болон давсан орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэх бол хэрэгцээ, шаардлага тодорхойлж, зайлшгүй хэрэгцээтэй хөрөнгийн жагсаалт, тоо хэмжээ, худалдан авах үнийн дээд хязгаарын саналыг дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч дэмжсэн тохиолдолд Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэлт санхүүжилтийн төсвөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгахдаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч бүртгэлд тусгаж тайлагнаж байх

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дээрх шийдвэрийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн албаны цалингийн нэгдсэн системд бодогдсон албан хаагчдын цалингаас 1,815.3 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгаж, төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.	1	1,815.3	1	1,815.3	-	-	-	-	-	-	-	-
2025 онд 5,689.9 мянган төгрөгийн хөрөнгийг нэмэлт төсвөөс худалдан авч ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүй хөрөнгөнд бүртгэж тайлагнасан байна.	1	5,689.9	-	-	-	-	1	5,689.9	-	-	-	-
Дүн	2	7,505.2	1	1,815.3	-	-	1	5,689.9	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 71/A0150061

Улаанбаатар хот

САГ-2026/104/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мал эмнэлгийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн албаны цалингийн нэгдсэн системд бодогдсон албан хаагчдын цалингаас 1,815,300.00 (нэг сая найман зуун арван таван мянга гурван зуун) төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгаж, төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт хэрэгжүүлж, мэдээ, тайлангийн уялдааг нягтлан шалгаж хэвших, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3-т "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-т "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7.1-т "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна", 7.1.1-т "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4 төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан хаагчдын цалингаас хувь хүний орлогын албан татварын 1,815,300.00 (нэг сая найман зуун арван таван мянга гурван зуун) төгрөгийг дутуу суутгаж, төсөвт төвлөрүүлээгүй нягтлан бодогч (А.Энхсайхан)-аар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мал эмнэлгийн хүрээлэнгийн захирал /Б.Батцэцэг/-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ТӨГСГҮҮД КОНСАЛТИНГ
АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Р.ДАВАА